



10. Гурван металлын дээж бүрийг халааж, хүчилтөрөгчтэй саванд зурагт үзүүлснээр байрлуулав. Туршилтаар дараах үр дүн ажиглагдсан бол өгсөн металлуудыг урвалын идэвхийн буурах дарааллаар жагсаана уу.



Металл	Үр дүн
X	Цог сүүмэлзсэн
Y	Дөл үүсгэн шатсан
Z	Тод цог үүсгэсэн

- A. X, Z, Y Б. X, Y, Z В. Y, Z, X Г. Y, X, Z

11. Зэсийн сульфатын талстыг зэсийн карбонат ба сулруулсан хүхрийн хүчлийн харилцан үйлчлэлээр гарган авдаг. Зурагт туршилтыг явуулсан 4 шатыг харуулжээ. Туршилтын үе шатыг зөв дарааллаар жагсаана уу.



- A. 2, 1, 3, 4 Б. 2, 3, 4, 1
В. 4, 3, 1, 2 Г. 4, 2, 3, 1

12. $\text{CH}_3\text{CH}_2\text{CH}_3$ нэрлэнэ үү.

- A. Метан Б. Этан В. Пропан Г. Бутан

13. Органик нэгдлийн изомериерг аль тохиолдолд хамгийн зөв тодорхойлсон байна вэ?

- A. Буцлах цэг ижил, хайлах цэгээрээ ялгаатай нэгдлүүд
Б. Найрлагаар ижил, бүтэц байгууллаараа ялгаатай нэгдлүүд
В. Физикийн шинж чанараараа ижил, химийн шинж чанараараа өөр нэгдлүүд
Г. Ижил функциональ бүлэгтэй ч давхар холбооны байршил өөр нэгдлүүд

14. Дараах нэгдлүүдийг буцлах цэгийн өсөх дарааллаар зөв байрлуулсан эгнээг сонгоно уу.

- I. $\text{CH}_2=\text{CH}-\text{CH}_3$ II. $\text{CH}_2=\text{CH}_2$ III. $\text{CH}_3-\text{CH}=\text{CH}-\text{CH}_3$
A. I<II<III Б. III<II<I В. III<I<II Г. II<I<III

15. 3-пропилгептантай изомер шулуун хэлхээтэй алканыг заана уу.

- A. 10 нүүрстөрөгчийн атомтай декан Б. 6 нүүрстөрөгчийн атомтай гексан
В. 9 нүүрстөрөгчийн атомтай нонан Г. 5 нүүрстөрөгчийн атомтай пентан

16. Аль нь нүүрсустөрөгч биш вэ?

- I. $\text{CH}-\text{COOH}$ II. $\text{CH}=\text{CH}$ III. $\text{CH}-\text{CH}-\text{OH}$ IV. $\text{C}_6\text{H}_6\text{O}_6$ V. CH_3-CH_3
A. I-V Б. I-II В. I, III, IV Г. II, V

17. Этанол ($\text{CH}_3\text{CH}_2\text{OH}$)-ын шатах урвалаар ямар нэгдлүүд үүсэх вэ?

- A. $\text{CH}_4 + \text{CH}_3\text{OH}$ Б. $\text{CO}_2 + \text{H}_2\text{O}$ В. $\text{C} + \text{H}_2$ Г. $\text{C} + \text{H}_2 + \text{O}_2$


18. Na_2SO_3 дахь хүхрийн исэлдэхүйн хэм хэд байна вэ?

- A. -2 Б. +2 В. +4 Г. +6

19. Хлорид ионыг ямар урвалжаар таних вэ?

- A. H_2SO_4 Б. NaOH В. BaSO_4 Г. AgNO_3

20. Цаасан хромаграммд аль нь цэвэр бодис байна вэ?



- A. 1
Б. 2
В. 3
Г. 4